



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/06

Аварга

**Өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|----------------------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч Ц.Цэцэгмаа | -Нийгмийн бодлогын түшмэл |
| Нарийн бичгийн дарга Б.Алтантуяа | -Сан хариуцсан нягтлан бодогч |
| Гишүүд | Д.Баярмаа -Тархвар зүйч |
| | У.Ариунтуяа - Байгаль орчны хяналтын улсын байцаагч |
| | А.Мөнхзул -Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэргэжилтэн |

2.Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу албан хаагч тус бүрийн картаар хариуцсан эд хогшил, техник тоног төхөөрөмжийг нүд үзэж зохион байгуулахдаа үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, Excel файл дээр төрөл тус бүрээр шийт үүсгэн, эд хөрөнгө бүрт QR код үүсгэн бүртгэлжүүлэхийг ажлын хэсгийн дарга (Ц.Цэцэгмаа), гишүүдэд, Тамгын газрын Нярав (Л.Баатархүү) нарт үүрэг болгосугай.

3.Эд хөрөнгийн үзлэг тооллогыг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулж, 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор нэгтгэж дүнг Нягтлан бодогч (О.Анхцэцэг), Нярав (Л.Баатархүү) нарт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Д.УРАНГОО

